

ИХЭРМӨРӨН-АУДИТ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосон илч ОНӨААТҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/008/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ОНӨААТҮГ-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цэхим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/309
танай _____ -ны № _____ -т

ТОСОН ИЛЧ ОНӨААТҮГ- ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БЯМБАЦОГТ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосон илч ОНӨААТҮГ- ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 26/24 дүгээр тогтоолоор компанийн өмчлөлийг Тосонцэнгал сумын ИТХ-д шилжүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Аудитаар нийт 117,932.4 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 117,932.5 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 1 албан шаардлага, нийцлийн аудиттай холбогдолтой 4 зөвлөмж өглөө.

Бусад асуудлын хэсэг

Тосон илч ОНӨААТҮГ- ийн тайлант жилийн орлогын төлөвлөгөө 100.2 хувиар давж, зардлын төлөвлөгөө 9.9 хувиар хэтэрч, 51,723.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүгнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн адийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ӨРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,388,855.99	7,524,055.37
1.1.2	Дансны авлага	14,298,933.00	23,442,458.80
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	24,994,645.12	13,632,972.92
1.1.6	Бараа материал	65,501,325.69	59,968,402.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	106,183,759.80	104,567,889.72
1.2.1	Үндсэн хөрөнгө	374,847,329.23	344,157,475.18
1.2.2	Биет бус хөрөнгө	13,572,000.00	13,572,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	388,419,329.23	357,729,475.18
1.3	Нийт хөрөнгийн дүн	494,603,089.03	462,297,364.90
2.1.1.1	Дансны өглөг	64,865,349.20	70,464,916.77
2.1.1.2	Цалингийн өглөг	2,419,425.00	-
2.1.1.3	Татварын өр	3,779,535.10	2,998,604.11
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	71,064,309.30	73,463,520.88
2.2	Өр төлбөрийн нийт дүн	71,064,309.30	73,463,520.88
2.3.1	-төрийн	249,127,532.91	264,339,132.91
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,913,603.18	14,913,603.18
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	159,497,643.64	109,581,107.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	174,411,246.82	388,833,844.02
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	494,603,089.03	462,297,364.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	567,184,788.18	589,670,359.37
2	Борлуулалтын өртөг	546,507,634.79	509,851,098.89
3	Нийт ашиг (алдагдал)	20,677,153.39	79,819,260.48
8	Бусад орлого	65,987,956.00	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	136,417,277.93	131,542,626.06
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		1,806,829.87
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(49,752,168.53)	(49,916,535.71)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	(49,752,168.53)	(49,916,535.71)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(49,752,168.53)	(49,916,535.71)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(49,752,168.53)	(49,916,535.71)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18		209,249,812.17	473,290,948.26
2	Залруулсан үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18		209,249,812.17	473,290,948.26

3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-49,752,168.53	-49,752,168.53
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18		159,497,643.64	423,538,779.73
2	Залруулсан үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18		159,497,643.64	423,538,779.73
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-49,916,535.71	-49,916,535.71
4	Бусад дэлгэрэнгүй орлого			15,211,600.0		15,211,600.00
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	249,127,532.91	14,913,603.18	15,211,600.0	109,581,107.93	388,833,844.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	619,293,128.51	639,951,106.86
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	618,640,370.51	639,951,106.86
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	106,958.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	545,800.00	
1.2	Мөнгөн зарлага (-)	614,934,242.2	608,111,607.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	249,676,007.32	182,172,130.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	35,443,115.22	57,698,449.36
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	112,898,847.50	97,480,684.93
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	68,840,888.91	81,327,093.4
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	88,293,218.00	123,501,715.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	33,728,076.74	41,227,626.43
1.2.9	Бусад мөнгөн зарлага	26,054,088.51	24,703,908.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,358,886.31	31,839,499.38
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	181,553,000.00	25,704,300.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		25,704,300.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	181,553,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(181,553,000.00)	(25,704,300.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-177,194,113.69	6,135,199.38
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	178,582,969.68	1,388,855.99
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,388,855.99	7,524,055.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
1	Халаалтын орлого	546,119,072.00	543,798,249.9	2,320,822.09	99.58
2	Цэвэр усны орлого	18,080,000	24,372,094.00	(6,292,094.00)	134.80
3	Хогны орлого	1,356,000	832,300.00	523,700.00	61.38
4	Халуун усны орлого	19,200,000	19,000,657.28	199,342.72	98.96
5	Хогны төлбөрийн орлого	3,840,000	1,667,058.18	2,172,941.82	43.41
6	Түрээсийн орлого				
7	Бусад орлого				
	Орлогын дүн	588,595,072.00	589,670,359.37	(1,075,287.37)	100.18
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	201,638,931	216,610,318.00	(14,971,386.80)	107.42
2	НДШимтгэлийн зардал	27,221,256	29,242,392.93	(2,021,137.23)	107.42
3	Нүүрс	54,905,000	56,977,148	(2,072,147.75)	103.77
4	Шатахуун	5,592,000	6,581,626.29	(989,626.29)	117.70
5	Тээврийн зардал	86,679,000	106,373,641.81	(19,694,641.81)	122.72
6	Гэрэл цахилгаан	82,693,100	81,327,093.40	1,366,006.60	98.35
7	Бичиг хэрэг	965,000	546,818.00	418,182.00	56.67
8	Цахилгаан холбоо	1,044,000	1,221,000.00	(177,000.00)	116.95
9	Албан томилолт	1,620,000	1,620,000	-	100.00
10	Ажиллаагүй үеийн НДШ	3,474,900.00	3,474,900.00	-	100.00
11	Хөдөлмөр хамгаалал	10,003,500	8,316,950.00	1,686,550.00	83.14
12	Урсгал засвар	9,600,000	6,981,737.81	2,618,262.19	72.73
13	Төлбөр хураамж	6,950,190	10,662,152.29	(3,711,962.29)	153.41
14	ТУЗ зардал	6,880,000	4,830,950.00	2,049,050.00	70.22
15	Түлээний зардал		800,000.00	(800,000.00)	
16	Тэтгэмж		15,452,848.00	(15,452,848.00)	
17	Сан техник сэлбэгийн зардал	10,563,900	12,334,006.94	(1,770,106.94)	116.76
18	Авто сэлбэг	5,641,000	2868181.81	2,772,818.19	50.85
19	Ажилчдын нийгэм хангамж	8,880,000.00	3,860,000.00	5,020,000.00	43.47
24	Элэгдлийн зардал	59,243,295	71,311,665.76	(12,068,370.76)	120.37
27	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	583,595,071.90	641,393,430.79	(57,798,358.89)	109.90
28	Үйл ажиллагааны бус орлого, зардал		1,806,829.87	(1,806,829.87)	
29	Татварын өмнөх ашиг, /алдагдал/	5,000,000.10	-51,723,071.42	56,723,071.52	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117,932.4 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 117,932.5 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 1 албан шаардлага, нийцлийн аудиттай холбогдолтой 4 зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлсэн 2,134.2 мянган төгрөгийн алдаа залруулсан
- Үндсэн хөрөнгийн тодруулга буруу илэрхийлсэн 25,704.3 мянган төгрөгийн алдаа залруулсан
- Бараа материалын орлогын бүртгэл буруу хийсэн 71,766.1 мянган төгрөгийн алдаа залруулсан
- Үр дүнгийн тайланд буруу илэрхийлсэн 15,211.6 мянган төгрөгийн алдаа залруулсан.
- Нүүрс тээврийн хөлсний ажил гүйлгээ е-баримт дутуу шивэгдснийг нөхөн шивүүлж 3,116.3 мянган төгрөгийн алдаа залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

- Тосон илч ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолын I баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний батлагдсан зардлыг 57,798.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах,” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бууруулсантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тосонцэнгэл сумын дараах төсөвт байгууллагуудтай дулааны гэрээ хийхдээ сумын ЗДТГ-аас 230 м3, ерөнхий боловсролын сургуулиас 1798,05 м3, Эрүүл мэндийн төвөөс 52.02 м3, Соёлын төвөөс 240,57 м3-ээр тус тус халаалтын талбайг бууруулж гэрээ хийсэн нь 32,271.7 мянган төгрөгийн орлого олох боломжийг алдсан нь Компаний тухай хуулийн 95.4. "Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна" гэсэн заалтад нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг арилгах

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19, зарлагын 33 гүйлгээ хугацаа хоцроож мэдээсэн ба 3 мэдээлэл огт мэдээлээгүй нь Засгийн Газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.10. “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” нийтэд мэдээлнэ заалттай нийцэхгүй бөгөөд Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

МУ-ын Засгийн Газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан хугацааг баримтлан мэдээлж байх.

3. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Тосон илч ХХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл

хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3,20.4 заалтад заасан ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
						Тоо	Дүн	Тоо	Дүн			
Мөнгөн гүйлгээний тайлан буруу илэрхийлсэн	2	2,134.2			2	2,134.2	2	2,134.2				
Үндсэн хөрөнгийн тодруулга буруу илэрхийлсэн	1	25,704.3			1	25,704.3	1	25,704.3				
Бараа материалын орлогын бүртгэл буруу	2	71,766.1			2	71,766.1	2	71,766.1				
Үр дүнгийн тайланд буруу илэрхийлсэн	1	15,211.6			1	15,211.6	1	15,211.6				
И баримт буруу шивсэн	1	3,116.3			1	3,116.3	1	3,116.3				
Дүн	7	117,932.5			7	117,932.5	7	117,932.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/	
		Үүнээс	

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Тосон илч” ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолын I хавсралтаар баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний батлагдсан зардлыг 57,798.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн.	1	0.0			1	0.0		
Төсөвт байгууллагуудтай дулааны гэрээ хийхдээ халаалтын талбайг бууруулж орлого олох боломжийг алдсан	1	-					1	
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Ахмадын сан байгуулаагүй байна.	1						1	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3,20.4 заалтын мэдээлийг ил тод мэдээлээгүй.	1						1	
Дүн	5	-				1	4	-



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 4/12270469/

Мөрөн сум

ХАА.2025/008/КА.МТ.ОМНГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тосон-Илч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тосон-Илч ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний нийт зардлыг 57,798.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохиж байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг төсөлн зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсвөт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй зооцож батлуулан биелэлтийг хангах, батлагдсан зардлын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосон-Илч ХХК-ийн захирал Д. Бямбацогт, нягтлан бодогч П. Мөнхбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А. ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР  Г. ИЧИНХОРЛОО

6724030625